

<http://mongol.cri.cn/21/2006/06/07/43@64380.htm>

(GMT+08:00) 2006-06-07 16:17:39

Монгол Хятад хоёр орны монгол судлаач эрдэмтэд хамтарч ажиллах нь маш чухал бөгөөд тийм сэдэв ч олон байна

Сурвалжлагч: О.Дарамбазар/ Хятадын Олон Улсын Радио



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б.Сумьяабаатар Бээжин Их Сургуулийн багш нартай ярилцаж байгаа нь

Сүүлийн жилүүдэд Хятад Монгол хоёр орны олон салбар дахь солилцоо, хамтын ажиллагаа маш түргэн хөгжиж, ялангуяа соёл, боловсрол, эрдэм шинжилгээний салбар дахь солилцоо, хамтын ажиллагаа нэн эрчтэй явагдаж, их дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллагууд хоорондын хэлхээ холбоо улмаар нягтарч, хамтын ажиллагааны цар хүрээ нь өргөжин тэлж чанар түвшин нь өндөржин дээшилж байгаа төдийгүй бас түүнийг цаашид нэн өргөжүүлэн гүнзгийрүүлэхийг хоёр орны эрдэмтэд хүсч байна.

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэнгийн Солонгос Судлалын Төвийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ахлах ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Б.Сумьяабаатар багшийг урилгаар саяхан Бээжин Их Сургуульд ирж эрдэм шинжилгээний лекц уншиж байсан үеэр, Хятадын Олон Улсын Радиогийн сурвалжлагч О.Дарамбазар түүнтэй уулзаж, Хятад Монгол хоёр орны монгол судлаач эрдэмтдийн солилцоо, хамтын ажиллагааны талаархи санал бодлыг нь сонссон юм.



2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн доктор, профессор Б. Сумьяабаатар Бээжин Их Сургуульд доктор, дэд профессор Дулаантай хамт байгаа нь

Сурвалжлагч: Багш та өнгөрсөнд Хятад улсад олон удаа ирж байсан. Хятад улсын өнөөгийн боловсрол болон эрдэм шинжилгээний ажлыг та яаж үнэлэх вэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Би Бээжин Их Сургуулийн Монгол Судлалын Төвийн байдалтай энэ удаа маш сайхан танилцлаа. Нэг тэмдэглэж хэлэх сайхан зүйл юу байна гэвэл, уг төвийн нарийн бичгийн дарга Дулаан багшийн удирдлагатайгаар уг төв нь эрдэм шинжилгээний залуу ажилтан нарыг маш сайн бэлтгэн хүмүүжүүлж байгаа явдал юм. Энд Цэцэг, Ариуна, Болор зэрэг гадаад хэлтэй, мөн Хятад улсад байгаа материал хэрэглэгдэхүүнүүдийг уншиж сайн эзэмшсэн, өөрөө бие дааж эрдэм шинжилгээний ажил хийж чадахаар болсон хэдэн сайхан залуу эрдэмтнийг бэлтгэж байгаа юм байна. Төв Азийн араб, перс хэлтэй хүн хүртэл энд бий. Энэ бол маш сайхан зүйл гэж би бодож байна. Бид ер нь хойш үеийнхнээ бэлтгэхэд маш их анхаарал тавих ёстой. Бээжин Их Сургуулийн эдгээр залуу эрдэмтдийн зарим нь Монгол улсад очиж байсан, бас зарим нь очоогүй юм байна. Тэгээд эрдэм шинжилгээний эдгээр залуу ажилтан нар Монгол улсад очиж сургалт хийгээсэй, Дулаан багш тэднийг Монгол улсад явуулж суралцуулаасай гэж хүсч байна. Бид тэднийг баяртай хүлээж авна.



**2006 оны 4-р сард Монгол Улсын Шинжлэх
Ухааны Академийн доктор, профессор Б.
Сумьяабаатар Бээжин Их Сургуулийн багш
оюутадтай ярилцаж байгаа нь**

Сурвалжлагч: Хятад Монгол хоёр орны эрдэмтэд эрдэм шинжилгээний салбар юм уу боловсролын салбарт хамтран ажиллах, солилцоо хийх нь монгол судлалын хөгжилд ямар үр нөлөө үзүүлнэ гэж та үзэж байгаа вэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Манай монгол судлаач эрдэмтэд Хятад улсан эрдэмтэдтэй хамтарч ажиллах нь маш чухал гэж би болож байна, тийм сэдэв ч бидэнд зөндөөн байна. Жишээлбэл Монгол улсын нутгаас Хятаны бага бичгийн дурсгал олдсон. Дээр үед Өвөр Монголын нутгаас ч Хятаны бага бичгийн дурсгал зөндөөн гарсан, гэхдээ Монгол улсад Хятаны бага бичгийн дурсгал байх тухай өнгөрсөнд огт мэдээгүй байсан юм.

Сурвалжлагч: Түүнийг аль онд илрүүлсэн бэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: 1980-аад оны үед илрүүлсэн, би өнөө түүний зургийг нь авч явж байна. Өчигдөр хятаны бичиг судлаач эрдэмтэн Лю багшийн нэг шавь нь миний дэргэд ирээд явсан, тэр хараад хятаны бага бичиг байна гэж хэлж байсан юм. Хятаны тэр бага бичгийг бид Монгол улсын төв хэсгийн Хэнтэй аймгаас хойш 70 километр зайтай газрын хадан дээрээс илрүүлсэн юм. Хэд хэдэн мэргэжлийн хүмүүс үзээд бүр хятаны бага бичиг байна гэж ярьж байсан. Түүнийг Хятад улсын эрдэмтэдтэй хамтарч судлах ёстой. Монгол улсад хятаны бичгийг судалж сонирхдог хүн байгаа боловч, хятаны бичгийг уншиж байгаа хүн байхгүй. Иймээс энэ бол та бүхэнтэй хамтарч ажиллах боломжтой зүйл гэж үзэж байна. Монгол улсад бас Зүрчид бичгийн дурсгал гарсан. Алтан улсын зүрчид бичгийн энэ дурсгал яахлаараа Монгол улсын нутагт үлдэв? гэдэг нь маш сонирхолтой асуудал байгаа юм. Тэр бичгийг бас Монгол улсын төв хэсгийн Хэнтэй аймгаас илрүүлсэн.

Сурвалжлагч: Тэр бичгийг мөн аль онд ямар газраас илрүүлсэн бэ?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Түүнийг 1986 оны баргаар илрүүлсэн, хуулбарыг нь би энд авчирсан. Хятад улсын багш нарт үзүүлсэнд тэд маш сонирхож байсан.

Сурвалжлагч: Түүнийг мөн хадан дээр бичсэн байсан уу?

Доктор, профессор Б. Сумьяабаатар: Тийн, түүнийг мөн хадан дээр бичсэн байсан. 12-р зууны үед Алтан улс урьд талаас нь Зүрчдийг цохиход, Чингис хаан наад талаас нь хавсарч өгсөн тухай мэдээ "Монголын нууц товчоон"-д байдаг. Тэр үеийн бичээс өөрөөр хэлбэл 1196 оны үеийн бичээс болов уу гэж гадны эрдэмтэд болон бид үзэж байна. Энэ бичээсийг бид Сэрвэн хаалга гэдэг газраас илрүүлсэн юм. Тэр чулуун бичээстэй газраас уул өөд нь жаахан өгсөх юм бол, хэдхэн метр яваад л нэг хятад бичээсийг олж харах юм. Тэр нь зүрчид бичээсний хятад орчуулга нь болов уу хэмээн эрдэмтэд үзэж судалж байна. Түүнийг Японы эрдэмтэд ч очиж үзсэн, харин Хятад улсын эрдэмтэд очиж үзсэн эсэхийг мэдэхгүй байна. Бид 1980-аад оны үеэр нэг өвөл очиж зургийг нь авсан юм, 2005 онд би даиж очиж үзсэн, жаахан эвдэрсэн байсан. Хятад бичээсний чулуу нь хуураад хуураад уначихсан болохоор нэлээд эвдэрсэн байдалтай байв. Тэр зүрчид бичээс нь дүрүү үзснээс нэлээд муутсан боловч, та бүхэн эрдэмтэд газар дээр нь очиж үзээд зургийг нь аваад судалж шинжлэх юм бол бас маш их сонирхолтой зүйл болох нь гэж бодож байна.

\О.Дарамбазар сурвалжилж редакторлов.\